



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтын үр дүн, үр нөлөө



**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ
ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт.....	2
Тэргүүлэх аудитор Д. Уламбаяр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3-5
Аудитын менежер Т.Байгалмаа	Нэг. Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	6-8
Ахлах аудитор Д. Нэргүйбаатар	Хоёр. Нийгмийн халамжийн сангаас олгох хүнс тэжээлийн дэмжлэгт зарим зорилтот бус иргэнийг хамруулсан, Ахмадын амралт сувиллын газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй байна.	8-10
Аудитор Н.Энхчимэг	Гурав. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хяналтын үр дүн тодорхойгүй байна.	10-10
2018 оны 06 дугаар сар	Дүгнэлт	11
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагын санал	12-13
www.audit.mn	Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар	14
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</i>	Зөвлөмж	15
ХАЯГ: <i>Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот</i>	Уламжлах санал	16

Товчилсон үгийн жагсаалт

АРА	АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
МУЗГ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
НХҮЕГ	НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР
НХҮГ	НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УБХ	УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
ЭБ	ЭРДЭНЭБУЛГАН СУМ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Нийгмийн халамжийн сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтын үр дүн, үр нөлөө

Аудитын код: АРА-/2018/01-ГА

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилтууд:

Нийгмийн халамжийн сангийн талаар төрөөс баримталж байгаа бодлого орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэнд хүрч байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, санал зөвлөмж боловсруулах олон нийтэд мэдээлэх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт оршлоо. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулсан эсэх
- Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөрөнгө нь зорилтод бүлэгт хүрч үр дүнтэй хэрэгжсэн эсэх
- Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх

Хамарсан хүрээ:

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын халамжийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас иж бүрэн шалгалт хийсэн байх тул аудитад аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2017 оны эхний 3 улирлын үйл ажиллагааны тайлан, халамжийн сангаас ахмад настны амралт сувиллын хөнгөлөлт олгох, хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйл ажиллагааны санхүүгийн анхан шатны баримтууд, дотоод хяналт шалгалтын баримт, материалуудыг хамруулан эрсдэлтэй асуудлыг түүвэрлэн шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 4000, 4100, Гүйцэтгэлийн аудитын журам, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан анхан шатны баримтаас түүвэрлэн нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгах, дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллага, албан тушаалтнаас тодруулга, тайлбар санал асуулга авах, шаардлагатай бол холбоотой талуудын баримтанд тулган шалгах, дахин тооцоолох, үр дүнг үнэлэх дүгнэх зэрэг арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн халамжийн тухай хууль
6. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
8. МУЗГ-ын 2015 оны 53 тогтоол
9. МУЗГ-ын 2012 оны 136 тогтоол
10. Монгол Улсын Хүн амын хөгжлийн, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 тоот тушаал /Хүнсний эрхийн бичиг олгох журам/
11. Монгол Улсын Хүн амын хөгжлийн, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/20 тоот тушаал /Хүнсний эрхийн бичиг олгох журам/
12. НХҮЕГ-ын даргын 2014 оны 04 сарын 23-ны өдрийн 66 дугаар тогтоол
13. Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандартууд

Хүндрэл бэрхшээл:

Уг аудитыг гүйцэтгэхээр томилогдсон аудитор нь эмнэлэгийн чөлөөтэй байсан хуулийн дагуу хэрэгжүүлэх Санхүүгийн тайлангийн аудит, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийх аудитад 2018.01.02-04.20-ныг хүртэл хугацаанд оролцсон шалтгааны улмаас төлөвлөсөн хугацаанаас хоцорч уг аудитын тайлан хүргэгдэж байгаад хүлцэл өчиж байна.

Оршил

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн НХҮГ-ын халамжийн сангийн бүрдүүлэлт зарцуулалт, харилцах, кассаас зарцуулсан мөнгөний баримтын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, тайлан гаргалт, өр, авлагын барагдуулалт, данс бүртгэлд тусгасан эсэх, өмнөх шалгалтын төлбөр, зөрчлийн барагдуулалт, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт зэрэгт 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Уг шалгалтаар 10.0 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлэн, төсөвт буцаан төвлөрүүлэх улсын байцаагчийн акт тогтоон барагдуулсан байна. Иймд аймгийн НХҮГ-ын халамжийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтыг аудитад хамруулаагүй болно.

Нийгмийн Халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар Халамжийн сан нь дараах 2 төрөлтэй байна.

- Тэтгэвэр, тэтгэмжийн сан;
- Нийгмийн үйлчилгээний сан

Аймгийн НХҮГ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д “Тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан зохион байгуулна” гэж заасныг хэрэгжүүлэхээс гадна Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль,

Хүний хөгжил сангийн тухай хуулиудад заасан хөнгөлөлт, тусламж, тэтгэмж олгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлдэг байна.

Аймгийн Нийгмийн Халамж Үйлчилгээний газар нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу 2016 оны 08 сарын 17-ны өдрөөс эхлэн аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийг нэгтгэн зохион байгуулагдаж нийт 50 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

2017 оны 3-р улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 39216 иргэнд 8.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, хүнс тэжээлийн тусламжийг тус тус үзүүлсэн байна. Тухайлбал:

- ✚ Халамжийн тэтгэвэрт 2233 иргэнд 2.4 тэрбум төгрөг,
- ✚ Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2275 иргэнд 1.1 тэрбум төгрөг,
- ✚ Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 2085 иргэнд 610.5 сая төгрөг,
- ✚ Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж 3270 иргэнд 349.2 сая төгрөг,
- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж 541 иргэнд 100.0 сая төгрөг,
- ✚ Жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжид 3535 иргэнд 744.3 сая төгрөг,
- ✚ Алдарт эхийн одонгийн тусламжид 8355 иргэнд 1.1 тэрбум төгрөг,
- ✚ Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 42 ахмадад 36.1 сая төгрөг,
- ✚ Насны хишигт 3859 ахмадад 624.6 сая төгрөг,
- ✚ Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2620 өрхийн 13009 иргэнд 1.1 тэрбум төгрөгийн хүнсний дэмжлэг тус тус олгосон байна.

Зарцуулалтын 29.2 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг халамжийн тэтгэвэрт, 13.4 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг нөхцөлт мөнгөн тэтгэмжид, 7.5 хувь буюу 0.6 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжинд, 13.4 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд тус тус зарцуулжээ.

Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хийсэн шалгалтын дүн болон төлөвлөлтийн шатанд цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцсон эрсдэлийн үнэлгээг харгалзан Халамжийн сангаас олгосон дараах үйлчилгээг 2017 оны байдлаар түүвэрлэн аудитад хамруулан шалгалаа.

Үүнд:

- Ахмад настны хөнгөлөлт, урамшуулал,
- хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилтын хүрээнд тодорхойлсон 3 чиглэлийн дагуу НХҮГ-ын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцан олж авсан мэдээллийг оруулсан бөгөөд аудитаар шалгасан 2 үйлчилгээний тухайд аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, баримт, материалд хийсэн дүн шинжилгээг тусгасан болно.

Бүлэг 1. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.1. Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан.

1.1.1 Нийгмийн халамжийн тэтгэврийг хуульд заасан эрх бүхий иргэнд олгосон байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийг “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “... нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно гэж заажээ. Үүнд:

- эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн;
- 16 насанд хүрсэн одой иргэн;
- хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд;
- 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.

Аймгийн ХХҮГ-ын Халамжийн сангаас 2017 оны 9 сарын байдлаар хуульд заасан эрх бүхий 2233 иргэнд нийт 2406.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр олгосон байна. Тэтгэвэр олголт тогтоолтыг ХХҮГ-ын дотоод хяналт шалгалтын нэгжээс шалгасан байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Халамжийн тэтгэврийн төрөл	Олгосон хүний тоо	Зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/
1	Ахмад настны тэтгэвэр	48	45.1
2	ХБИ иргэний тэтгэвэр	1591	1668.6
3	16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1.1
4	Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	593	691.6
Дүн		2233	2406.4

Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын 2017 оны хөрөнгийн орлого, зарлагын мэдээ, тайлан

1.1.2 Нийгмийн халамжийн тэтгэмжийг хуульд заасан зорилтот иргэнд олгосон байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д халамжийн тэтгэмжийг дараах төрөлтэй байхаар заажээ. Үүнд:

- Асаргааны тэтгэмж;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж;
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж.

Халамжийн сангаас 2017 онд хуульд заасан зорилтот 4333 иргэдэд нийт 1639.5 сая төгрөгийн тэтгэмжийг олгожээ. Үүнийг тэтгэмжийн төрлөөр хүснэгтээр харуулбал:

№	Халамжийн тэтгэмжийн төрөл	Олгосон хүний тоо	Зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/
1	Асаргааны тэтгэмж	108	56.5
1.1	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран	77	40.3

	хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэний тэтгэмж		
1.2	Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	18	9.8
1.3	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	13	6.4
2	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, ХБИ-ийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны иргэнд олгох тэтгэмж	2169	990.5
3	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	2056	592.5
	Дүн	4333	1639.5

Эх сурвалж: ХХҮГ-ын хөрөнгийн орлого, зарлагын мэдээ, тайлан

1.2. Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.2.1 Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нийгмийн үйлчилгээний сангаас нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг санхүүжүүлдэг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 17.1-д зааснаар “Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй. Үүнд:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

аймгийн ХХҮГ-ын халамжийн сангаас 2017 оны эхний 9 сард Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 6 иргэнийг хамруулж нийт 6.0 сая төгрөг зарцуулсан ба төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хөрөнгө зарцуулаагүй байна.

1.2.2 Нийгмийн хөгжлийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нийгмийн хөгжлийн үйлчилгээ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт тодорхойлсноор

- Боловсролыг дэмжих үйлчилгээ
- Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ гэсэн төрөлтэй байна.

Аймгийн ХХҮГ-ын 2017 оны 9 сарын санхүүгийн баримт материалаас харахад боловсролыг дэмжих, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд сангаас хөрөнгө зарцуулаагүй байна. Харин хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 13207 иргэнийг хамруулж 1089.4 сая төгрөгийг олгожээ.

Үүнээс гадна Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хуульд заасан хөнгөлөлт, тэтгэмж, тусламжийг хуулиар тодорхойлсон зорилтот бүлгийн иргэдэд олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

1	Ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	2614	343.9
2	ХБИ-ний тусламж, хөнгөлөлт	516	110.9
3	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	3536	722.9
4	Алдарт эхийн одонгийн тусламж	8299	1122.3
5	Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	23	35.7
6	Насны хишгийн зардал	3945	624.5
	Дүн	18933	2960.2

Эх сурвалж: ХХҮГ-ын хөрөнгийн орлого, зарлагын мэдээ

Бүлэг 2. Нийгмийн халамжийн сангаас олгох хүнс тэжээлийн дэмжлэгт зарим зорилтот бус иргэнийг хамруулсан байна.

2.1. Нийгмийн халамжийн үйлчилгээ үр дүнтэй хэрэгжсэн байна.

аймгийн ХХҮГ-ын халамжийн сангаас 2017 оны эхний 9 сард Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 6 иргэнийг хамруулж нийт 6.0 сая төгрөг зарцуулсан нь үр дүнтэй хэрэгжсэн байна. Харин төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хөрөнгө зарцуулаагүй байна.

2.2. Нийгмийн халамжийн сангаас олгох хүнс тэжээлийн дэмжлэгт зарим зорилтот бус иргэнийг хамруулсан байна.

Аймгийн ХХҮГ-ын халамжийн сангаас 2017 оны эхний 9 сард Боловсролыг дэмжих үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд хөрөнгө зарцуулаагүй байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 13207 иргэнд 1089.4 сая төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын Хүн Амын Хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны а/32 тоот тушаалаар “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд амьжиргааны түвшинг тодорхойлсон судалгааг үндэслэн хүнсний эрхийн бичгийг том хүн 13000 төгрөг, хүүхэд 6500 төгрөг” байхаар тогтоосон байна.

2017 оны 9 сарын байдлаар хүнсний эрхийн бичгийн талонд аймгийн хэмжээнд 19 суманд нийт 13207 иргэнд 1089.4 сая төгрөгийн хүнсний эрхийн бичгийн дэмжлэг олгожээ. /Сум тус бүрээр гаргасан дэлгэрэнгүйг Судалгаа №2 ээс үзнэ үү/

Зөвхөн Эрдэнэбулган сумын хэмжээнд 2017 оны эхний 10 сарын байдлаар 541 өрхийн 2889 иргэн хамрагдаж 269.4 сая төгрөгийн хүнсний бүтэгдэхүүнийг 10 дэлгүүрээр дамжуулан олгосон байна.

Аудитаар Эрдэнэбулган сумын хүнсний дэмжлэгт хамрагдсан нийт иргэдээс санамсаргүй түүврийн аргаар 7 багийн 84 өрхийг түүвэрлэн сонгон авч аудитад хамруулан шалгалаа.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны дарга, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 123/165 тоот хамтарсан тушаалаар баталсан “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны асуулга” маягтаар дээрх өрхөөс НХҮГ-ын мэргэжилтнүүдийн авсан судалгааг Эрдэнэбулган сумын ЗДТГазар, Улсын Бүртгэлийн Хэлтэс, Тээвэр Авто Замын Газраас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад дараах зөрчлүүд илэрсэн болно. Үүнд:

1. УБХ-ээс ирүүлсэн судалгаатай харьцуулан тулган шалгахад Эрдэнэбулган сумын тухайн багт оршин суух бүртгэлгүй иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг олгосон байна. Тухайлбал:
 - ЭБ сумын 1-р багт оршин суудаг гэж дэмжлэгт хамрагдсан Д.Бадрах нь 2013 оны 04 сарын 04-ны өдөр Цэнхэр сумаас шилжилт хөдөлгөөн хийгдсэн бөгөөд Булган сумын 4-р багт оршин суудаг бүртгэлтэй байна.

- ЭБ сумын 1-р багт оршин суудаг гэж дэмжлэгт хамрагдсан Ц.Ганхуяг нь Цэцэрлэг сумын 5-р багт бүртгэлтэй, хувийн хэргийн маягтанд шилжилт хөдөлгөөнд хийгдсэн нотлох баримтгүй байлаа.
 - ЭБ сумын 5-р багт оршин суудаг гэж дэмжлэгт хамрагдсан иргэн Ж.Пүрэвжанцан нь Булган сумын 4-р багт бүртгэлтэй байна.
2. Түүвэрт хамрагдсан өрхөөс “Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа”-нд автотээврийн хэрэгсэл байхгүй гэж мэдүүлэн 2 буюу дунджаас доогуур гэсэн үнэлгээ авсан нэр бүхий 10 иргэн нь Тээвэр авто замын газраас ирүүлсэн судалгаанд автотээврийн хэрэгслийн эзэмшигч гэж бүртгэгдсэн байна. /Хавсралт судалгаа №3/
3. Түүвэрт хамрагдсан өрхөөс “Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа”-нд мал амьтангүй гэж мэдүүлэн 2 буюу дунджаас доогуур гэсэн үнэлгээ авсан 4 өрх нь Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас ирүүлсэн судалгаагаар 98-288 толгой малтай гэсэн бүртгэлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь **зөвхөн** Эрдэнэбулган сумын хэмжээнд хийсэн судалгаа мэдээллүүдийг харьцуулж тулган шалгахад илэрсэн бөгөөд **энэ нь** аймгийн хэмжээнд ч тохиолдож болох магадлалтайг харуулж байна. Эдгээр зөрчил гарах болсон гол шалтгаан нь төрийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, мэдээллийг харилцан солилцдоггүй, өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгааг гаргахдаа багийн засаг дарга, нийгмийн ажилтантай хамтран ажиллаагүй зэрэг холбоотой гэж үзэж болохоор байна.

Үүний улмаас нийгмийн халамжийн сангаас иргэдэд олгох хүнс тэжээлийн дэмжлэг нь зорилтод бүлэгт бүрэн зориулагдаж чадахгүйд хүрч болзошгүй байна. Харин 2017 оны 04 дүгээр сараас эхлэн Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг дахин шинээр хийж 2017 оны 11 дүгээр сараас дээрх байгууллагуудаас мэдээллийг авч тулган шалгаж баталгаажуулдаг болсон нь дээрх зөрчлүүд гарахгүй байхад үр нөлөөтэй болохоор байна.

Мөн энэ зорилтын хүрээнд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу “Ахмад настанд амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох” арга хэмжээний үр дүнг түүвэрлэн шалгалаа.

Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу ахмад настны амьжиргааг дэмжих хөнгөлөлт урамшуулалд 2017 оны эхний 10 сарын байдлаар нийт 3342 ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлтөнд 351.8 сая төгрөг зарцуулсныг анхан шатны баримтаар тулган шалгалаа. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д заасан “хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа, шүд /үнэт металаар хийхээс бусад/-ний протезийн дотоодод хийлгэсэн зардлын үнийг гурван жилд нэг удаа тус тус нийгмийн халамжийн сангаас нөхөн олгоход 1061 ахмад 158.2 сая төгрөг
- 8.1.3-д “тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, тусламжаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгоход 31 ахмадад 4.3 сая төгрөг
- 8.1.4-д заасан “нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох” 1 ахмад 0.7 сая төгрөг,
- 8.1.2-д заасан “ахмад настанд амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох” зориулалтаар 1056 ахмадад 176.7 сая төгрөг тус тус зарцуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 94 дүгээр тогтоолоор “Ахмадын зориулалттай амралт сувиллын газарт ахмад настан хөнгөлттэй үнээр амарч сувилуулах хугацааг 10 хүртэл хоногоор тогтоож нийгмийн халамжийн хэлтсийн ахмадын сувилалын газраас бусад амралт сувиллын газарт 1 өдрийн ор хоног 20.0 мянган төгрөг байх”-аар тогтоосон байна.

Аудитын явцад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Ахмадын зориулалттай амралт сувиллын газруудад МУЗГ-ын 2016 оны 94 тогтоолын дагуу ахмад настан хөнгөлөлттэй үнээр амарч сувиллуулсны төлбөрт нийт 388 ахмад настны 76.5 сая төгрөгийг олгосныг анхан шатны баримтаар тулган шалгалаа.

- Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Бор талын хишиг ХХК-ны "Сувд" амралт сувиллын газар нь ХХҮЕГазрын 2017.05.23-ны өдрийн 1/849 тоот албан бичгээр ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарч гэрээ байгуулсан байна.
- Харин “Хасу” шивэрт амралт сувиллын газар ХХҮЕГазрын 2017.09.21-ны өдрийн 7/1430 тоот албан бичгээр магадлан итгэмжлэлийг сунгаж, ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх эрх олгосон байна.

Дээрх гэрээг үндэслэн ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлж байгаа “Хасу шивэрт”, Бор талын хишиг ХХК-ны "Сувд" амралт сувиллын газруудтай ХХҮЕГазрын дарга нь Ахмад настны тухай хуулийн 5 зүйлийг хэрэгжүүлэхээр 42 тоот гэрээг байгуулсан бөгөөд гэрээний дагуу 2017 оны эхний 9 сарын байдлаар халамжийн сангаас “Хасу шивэрт” амралт сувиллын газар нь 16 ахмадыг амрааж 3.2 сая төгрөгийг халамжийн сангаас авч эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт аваагүй байна. Харин Бор талын хишиг ХХК-ны "Сувд" амралт сувиллын газар 96 ахмадыг амрааж Халамжийн сангаас 19.0 сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас 13.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

“Сувд” амралт сувиллын газар нь Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын даргатай байгуулсан гэрээний 2.28-д ***“Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 зүйлд заасан үйлчилгээ үзүүлэх эрх авсан амралт сувиллын байгууллага нь ахмад настны амралт сувиллын эрхийн бичгээр амарч, сувиллуулсан хугацаанд давхардуулан Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдлэхийг хориглоно”*** гэсэн заалтыг зөрчиж Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сангаас 22 ахмадын **4.4** сая төгрөгийг давхардуулан авсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо. Мөн 1 ахмадыг жилд 2 удаа амрааж Эрүүл мэндийн даатгал сан, халамжийн сангаас **14.6** сая төгрөгийг авсан зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ. /Дэлгэрэнгүйг Судалгаа №1 ээс үзнэ үү/

Бүлэг 3. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод хяналтын үр дүн тодорхойгүй байна.

3.1. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн.

ХХҮГ-ын захиргаа хяналтын хэлтсээс халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд 2017 оны 1-р улиралд нэг удаа хяналт шалгалт хийж цаашид хэрэгжүүлж ажиллах 8 заалт бүхий саналыг гаргасан байна. Гэвч уг саналыг хэн хэрэгжүүлэх, дээрх хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүнг тооцсон баримт материал ХХҮГ-т алга байгаа буюу дотоод хяналтын үр дүн тодорхойгүй байна.

3.2. Өмнөх аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

Аймгийн Аудитын газраас аймгийн НХҮГ-ын нийгмийн халамжийн сангийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж хамрагдсан асуудлын хүрээнд зөрчил илрээгүй тул менежмент захидлаар ямар нэг зөвлөмж хүргүүлээгүй байна.

-----О-----

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн хамрагдсан асуудлын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
2. Нийгмийн халамжийн сангаас олгох хүнс тэжээлийн дэмжлэгт шалгалтанд хамрагдах хугацаанд зарим зорилтод бүлгийн бус хүмүүсийг хамруулсан байна. Ахмадын амралт сувиллын газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй байна.
3. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод хяналтын үр дүн тодорхойгүй байна.

Аудитаар нийт 19.0 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрсний 14.6 сая төгрөгийг зөрчлийг арилгуулах албан шаардлага, Халамжийн сан болон Эрүүл мэндийн даатгалын сангаас давхардуулан авсан 4.4 сая төгрөгийн төлбөрийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Холбогдох байгууллагын санал



АРХАНГАЙ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

65141 Архангай аймаг, Эрдэнэбулган сум,

Утас/Факс: (976) 7033 2583,

И-мэйл: info@arkhangai.hudulmur-halamj.gov.mn

2018.03.29 № 155

ТАНГАЙ _____-НЫ № _____-Т

Тайлбар хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.УЛАМБАЯР ТАНАА

Д.Уламбаяр

Тайлбар хүргүүлж байна!

Д.Уламбаяр

Архангай аймаг дахь төрийн аудитын газраас Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төслийн дүгнэлтэд дараах тайлбар өгч байна.

Нэг. Одоогийн байдлаар Архангай аймагт статистик тоогоор 8101 ахмад настан амьдарч байна.

2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр шинэчлэн баталсан "Ахмад настны тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Ахмад настны амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулахад төрөөс үзүүлэх дэмжлэгүүдийг заасан байдаг.

Мөн 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197-р тогтоолоор "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам"-ыг баталсан. Эдгээр хууль эрх зүйн актын хүрээнд тус газар нь 2017 оны эхний 9 сарын байдлаар 3270 ахмад настанд 349 200.0 мян төгрөгийн хөнгөлөлт тусламжийг олгосон байна.

2017 онд ахмад настанд амралт сувилалын үйлчилгээ үзүүлэх эрх авсан "Бор талын хишиг" ХХК-ны "Сувд" сувилал нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай 1500 ахмад настанд амралт, сувилалын үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан байх бөгөөд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь өөрийн төсвийн хүрээнд тус сувилалд үйлчлүүлсэн 187 ахмад настны 37160.0 мян төгрөгийн хөнгөлөлтийг холбогдох материалыг нягтлан үзэж шилжүүлсэн. Тухайн үед ирүүлсэн баримтаас үзэхэд нийгмийн даатгалын сангийн ямар нэгэн хөнгөлөлт тусламжид хамрагдаагүй, зөрчил дутагдалгүй байдаг. Тус сувилал нь халамжийн сангаас хөнгөлөлт аваад хэдэн сарын дараа ахмадуудыг нийгмийн даатгалын санд дахин хамрагдуулан хөнгөлөлт авч давхардал үүсгэсэн байна. Энэ нь тухайн байгууллагын санаатай гаргасан зөрчил мөн бөгөөд нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай бас холбоотой гэж үзэж байна. Иймд "Ахмад настны хөнгөлөлт урамшуулалд олгох хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна" гэсэн дүгнэлтийг эргэн харна уу.

Хоёр. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар 2013 онд анх удаагаа "Орлогыг орлуулан тооцох аргачлал"-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг зохион байгуулсан. Судалгааны зохион байгуулалт нь батлагдсан маягтын дагуу өрхөөс асуулга авч, асуулганд хариулагчийн аман мэдээлэл дээр тулгуурлан, тухайн иргэний гарын үсгийг зуруулан баталгаажуулж мэдээллийн санд оруулснаар эцсийн хариу гардаг байснаас иргэд мэдээллээ буруу өгөх, судалгааны

010023

үед зарим сумдад өмч хөрөнгөө нуун дарагдуулах зэргээр мэдээллээ худал мэдүүлж халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж байсан. 2017 онд Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны аргачлал, судалгааны зохион байгуулалт шинэчлэгдэн өрх иргэнээс авсан мэдээллийн үнэн зөв бодит байдлыг хангах зорилгоор амаар авсан судалгаагаа мал тооллогын сан, авто тээврийн бүртгэлийн сан, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын сан зэрэг байгууллагуудтай тулган шалгаснаар нийт судалгаанд хамрагдсан өрхүүдээс 11422 өрхийн мэдээлэл зөрүүтэй ирж мэдээллийн үнэн зөв бодит байдлыг баталгаажуулж ажилласны үр дүнгээр аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ 1000 гаруй өрхөөр цөөрсөн.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа нь тухайн иргэний харъяалал хаана байгаагаас үл хамааран оршин сууж байгаа газарт нь судалгааг авч амьжиргааны түвшний үнэлгээг гаргадаг. Өөрөөр хэлбэл өөр аймаг хотод бүртгэлтэй иргэн манай аймагт түр хугацаагаар өрхөөрөө оршин сууж байгаа тохиолдолд бид судалгааг зайлшгүй авах нөхцөл бүрддэг. Аймгийн төвтэй ойрхон Булган, Цэнхэр, Ихтамир, Батцэнгэл сумын харъяат өрхүүд Сангийн толгойн гүүр, Урт булаг, Шарга морьт, Майдар чулуу зэрэг Эрдэнэбулган сумын ойролцоо газарт оршин суудаг мөн Эрдэнэбулган сумын 6-р багийн өрхүүд Батцэнгэл сумын нутаг дэвсгэрт оршин суудаг зэрэг онцлог нөхцөл байдлаас шалтгаалан оршин сууж байгаа газарт нь судалгаанд хамруулах зайлшгүй шаардлага байдаг. Мөн зорилтот бүлгийн иргэд өөрийн гэсэн хашаа, газар байхгүйн улмаас айл айлын хашаа дамжин нүүж амьдардагаас сумаас суманд, багаас багт шилжихдээ шилжилт хөдөлгөөн хийдэггүй. Энэ нь тухайн зорилтот бүлгийн өрх гэрийн иргэний бүртгэл мэдээллийн асуудлаа цэгцлэх үүрэг хариуцлага, амьдралын нөхцөл боломж, Улсын бүртгэлийн байгууллагын хяналт үйлчилгээ, засаг захиргааны анхан шатны нэгжийн бүртгэл хяналт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж иргэдийн хаягийн зөрчил арилахгүй байгаатай холбоотой юм. Иймд "Хүнс тэжээлийн дэмжлэгт олгож байгаа хөрөнгө нь зорилтот бүлэгт бүрэн хүрч үр дүнтэй хэрэгжээгүй байна" гэсэн дүгнэлтийг эргэн харахыг хүсье.

Хүндэтгэсэн:

ДАРГА

Д.МӨНХБАТ



Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар

1-рт: “Ахмад настны хөнгөлөлт урамшуулалд олгох хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна” гэсэн дүгнэлтийг эргэн харна уу гэснийг хүлээн авч нягтлан үзээд ахмад настны амралт сувилалд жилд 1 удаа хөнгөлөлтэй үнээр амруулах зорилгоор ХХҮЕГ болон Бор талын хишиг ХХК-ний хооронд 2017 оны 05 сарын 12-ний өдөр байгуулсан гэрээний амралт сувиллын газрын эрх үүрэг буюу 2.28-д **“Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 зүйлд заасан үйлчилгээ үзүүлэх эрх авсан амралт сувиллын байгууллага нь ахмад настны амралт сувиллын эрхийн бичгээр амарч, сувиллуулсан хугацаанд давхардуулан Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдлэхийг хориглоно”** гэснийг Бор талын хишиг ХХК-ний “Сувд” сувиллын газар зөрчсөн бөгөөд уг гэрээний 3.1-д заасан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих эрхийг аймгийн ХХҮГ нь хэрэгжүүлээгүй байна. Иймд ахмадын амралт сувилалтай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй байна гэж дүгнэлтийг өөрчиллөө.

2-рт: Хүнс тэжээлийн дэмжлэгт олгож байгаа хөрөнгө нь зорилтот бүлэгт хүрч үр дүнтэй хэрэгжээгүй байна” гэсэн дүгнэлтийг эргэн харна уу гэснийг хүлээн авч 2017 оны 04 дүгээр сараас эхлэн Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг дахин шинээр хийж 2017 оны 11 дүгээр сараас Улсын бүртгэлийн хэлтэс, Авто тээврийн газар, сумын ЗДТГ зэрэг байгууллагуудаас иргэдийн мэдээллийг авч тулган шалгаж баталгаажуулдаг болсон байх тул шалгалтанд хамрагдах хугацаанд Нийгмийн халамжийн сангаас олгох хүнс тэжээлийн дэмжлэгт зарим зорилтот бүлгийн бус иргэнийг хамруулсан байна гэж тус тус өөрчиллөө.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн НХҮГ-ын дарга Д.Мөнхбатад:

1. “Өрхийн амьжиргааны түвшин тогтоох” судалгаанд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Авто тээврийн газар, Татварын хэлтэс зэргүүд байгууллагуудын бүртгэлийн мэдээлэл, сумдын иргэний бүртгэл мэдээллийн лавлагаа зэрэг мэдээллийг ашиглаж тулган баталгаажуулах, хуурамч баримт материал бүрдүүлэн зорилтот бус иргэн хамруулах эрсдлийг бууруулах арга хэмжээ авах
2. Ахмад настны тухай хуулийн 8.1.2-д заасан “ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох” арга хэмжээг хэрэгжүүлэх сувиллын газарт хөнгөлөлтийг тооцож олгохдоо аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын газраас хэвтэн эмчлүүлсэн төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас авсан эсэхийг тулган шалгаж НХҮЕГ-тай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах

Зөвлөмжийг хэрэгжүүлснээр дээрх зориулалтаар төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах, зарцуулалтанд тавих хяналт сайжрах болно.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

УЛАМЖЛАХ САНАЛ

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын явцад Ахмад настны амралт сувилалд хөнгөлөлттэй үнээр амруулахаар ХХҮЕГ-тай гэрээ байгуулсан “Бор талын хишиг” ХХК-ний “Сувд” сувилал нь гэрээний 2.28 дахь заалтыг зөрчиж ахмад настны амралт сувиллын эрхийн бичгээр амарч, сувилуулсан хугацаанд давхардуулан Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдэлсэн өөрөөр хэлбэл халамж болон эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлтийн санхүүжилтийг давхардуулан авсан 4.4 сая төгрөгийн, жилд 2 удаа амруулсан 14.6 сая төгрөгийн нийт 19.0 сая төгрөгийн зөрчил илрээд байна. Энэхүү зөрчил нь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас ХХҮГ-ын халамжийн сангийн 2016 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар мөн илэрч байсан бөгөөд 10.0 сая төгрөгийн акт тогтоогдсон байна. Тодруулбал амралт сувиллын газар нэг ахмад настны бичиг баримтаар Халамжийн сан, Эрүүл мэнд нийгмийн даатгалын сан гэсэн 2 өөр сангаас санхүүжилт давхардуулан авч байна.

Улсын хэмжээнд 80 гаруй ахмад настны амралт сувиллын үйлчилгээ үзүүлдэг байгууллага байгаа бөгөөд энэ төрлийн зөрчил байж болзошгүй юм. Иймд дээрх зөрчлийг арилгуулах төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийгмийн Халамж Үйлчилгээний Ерөнхий Газарт уламжилж өгнө үү.

- Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д “Ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох” заалтын дагуу ХХҮЕГ сувиллын газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулахдаа уг сувилалд ахмад настны амралт сувиллын эрхийн бичгээр амарч, сувилуулсан хугацаанд давхардуулан Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт эдлэхгүй байхад тавих тухайн амралт сувиллын газрын харъяа ХХҮГ-ын хяналт, хариуцлагын тогтолцоог тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна.

Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг давхардуулан зарцуулж байж болзошгүй зөрчил улсын хэмжээнд таслан зогсоогдож, тодорхой хэмжээний улсын төсвийн хөрөнгө арвилан хэмнэлттэй зарцуулагдах болно.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР